

БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



## САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Булган аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: БУА-2020/1/СТА-ТЕЗ

Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)

Булган аймаг

2020 он

Булган аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,  
тэргүүлэх аудитор: Д.Анхбаяр

Утас: 70342580 Цахим хаяг: Ankhbayard@audit.gov.mn

Аудитын менежер: Ж.Энхцоодол

Утас: 70342716 Цахим хаяг: Enkhtsoodolj@audit.gov.mn

Ахлах аудитор: П.Содном

Утас: 70342495 Цахим хаяг: Sodnomp@audit.gov.mn

## Агуулга

1. Аудитын гэрчилгээ .....	3
2. Аудитын тайлан .....	5
2.1. Оршил.....	
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага .....	
2.3. Аудитын явцад МӨРДСӨН БОДЛОГО, ЖУРАМ, АРГА ЗҮЙ, ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ .....	
2.4 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	6
2.5 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ .....	6
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал .....	7
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....	7
2.8.1 Мөнгөн хөрөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө .....	7
2.8.2 Богино хугацаат хөрөнгө оруулалт .....	
2.8.3 Авлага.....	10
2.8.4 Урьдчилгаа .....	13
2.8.5 Урт хугацаат хөрөнгө оруулалт .....	
2.8.6 Бараа материал .....	14
2.8.7 Үндсэн хөрөнгө.....	15
2.8.8 Урт хугацаат хөрөнгө оруулалт .....	
2.8.9 Өр төлбөр.....	17
2.8.9 Засгийн газрын хувь оролцоо.....	19
2.9 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн .....	20
2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга.....	
2.13. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	
2.14. Аудитын зөвлөмж.....	
3. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	33
3.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан.....	33
3.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан.....	35
3.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	39
3.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	43
3.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	44
3.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан .....	<b>Error! Bookmark not defined.</b>
4.Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт .....	

**Товчилсон үгийн жагсаалт**

<b>ТӨЗ</b>	<b>Төсвийн ерөнхийлөн захирагч</b>
<b>УСНББОУС</b>	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
<b>ОНААТҮГ</b>	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
<b>ТАБ</b>	Төрийн аудитын байгууллага
<b>СТА</b>	Санхүүгийн тайлангийн аудит
<b>ОНТБ</b>	Орон нутгийн төсвийн байгууллага
<b>ААНБ</b>	Аж ахуйн нэгж байгууллага
<b>НДШ</b>	Нийгмийн даатгалын шимтгэл
<b>ОНХС</b>	Орон нутгийн хөгжлийн сан
<b>ТЗС</b>	Тусгай зориулалтын сан
<b>ЗДТГ</b>	Засаг даргын тамгын газар
<b>ИТХ</b>	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
<b>БХС</b>	Байгаль хамгаалах сан
<b>ХХК</b>	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
<b>НББ</b>	Нягтлан бодох бүртгэл
<b>СХС</b>	Сум хөгжүүлэх сан

## 1. Аудитын гэрчилгээ



**БУЛГАН АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

63082 Булган аймаг, Булган сум, Жаргалант баг,  
Утас: 7034-2580, Факс: 7034-2580

2020.04.20 № 168

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ т

БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА,  
ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧ  
З.БАТЗОРИГ ТАНАА

### Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.4-д заасны дагуу Булган аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, тодруулгад санхүүгийн тайлангийн аудит хийв.

### Хязгаарлалттай санал дүгнэлт

Аудитын гол асуудалд дурдсан алдаа, зөрчлийг эс тооцвол Булган аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул хязгаарлалттай санал дүгнэлт гаргаж байна.

### Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Булган аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, тодруулга дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

### Аудитын гол асуудал

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд нэгтгэгдсэн Булган, Тэшиг, Хутаг-Өндөр, Сэлэнгэ сумдын төсвийн төвлөрүүлэн захирагч, орон нутгийн төсвийн 13 шууд захирагч нийт 17 санхүүгийн тайланд "Хязгаарлалттай", аймгийн Нөөцийн газрын санхүүгийн тайланд "Татгалзсан" дүгнэлт тус тус өгөгдсөн,

Хутаг-Өндөр сумын ерөнхий боловсролын сургууль, Уньт бага сургууль, Хантай бага сургууль нь НББ-ийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3, 6 дугаар зүйл, 20 дугаар зүйлийн 20.2.1, 20.2.3, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 26 дугаар зүйлийн 26.1 дэх заалтыг зөрчиж, жилийн эцсийн санхүүгийн тайланг стандарт, санхүүгийн программаар гаргаагүй, аудитын түүвэрлэлт хийх хангалттай, зохистой нотлох баримт олж авах боломжгүй, баримт бичгийн эмх цэгц, бүрэн бүтэн байдал хангалтгүй тул төсвийн ерөнхийлөн захирагчийн нэгтгэсэн санхүүгийн тайланд санхүүжилтийн 1372.0 сая төгрөгөөр алдаа, зөрчил тооцсон,

Аймгийн байгаль хамгаалах сангийн санхүүгийн тайлангаар 242.0 сая төгрөгийн 9 сум, "Ленда" ХХК-тай холбоотой нөхөн сэргээлт, ойжуулалтын авлагыг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй,


Сум хөгжүүлэх сангийн зээлийн авлагын барагдуулалтад ахиц гараагүй хугацаа хэтэрсэн 526 иргэн, ААН байгууллагын 1883.1 сая төгрөгийн үлдэгдэлтэй, төрийн сангийн авлага 212.7 сая төгрөгийн үлдэгдэлтэй үүнээс 1996-2002 онуудад үүссэн хүнс, өвс тэжээл, зээл зэрэг 75.3, 2008 онд "Атрын III" аяны хүрээнд иргэдэд эргэн төлөгдөх нөхцөлөөр олгосон зээлийн авлага 137.4 сая төгрөгийн авлагыг барагдуулах талаар өмнөх оны СТА-аар өгөгдсөн боловч тодорхой ажил зохион байгуулаагүй, авлага барагдуулах арга хэмжээ аваагүй,

Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд нэгтгэгдсэн төсөв захирагчдын санхүүгийн тайланд хийсэн аудитаар худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулаагүй, батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулаагүй, анхан шатны баримтын бүрдэл дутуу ажил гүйлгээг гүйцэтгэж, бүртгэл тайланд тусгасан, авлага, өр төлбөрийн үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй цалин, урамшууллыг давхардуулан олгосон, эрх мэдлээ хэтрүүлэн ашигласан гэх мэтчилэн нийт 3556.3 сая төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил илэрсэн зэрэг нь санхүүгийн тайлангийн оршин байх, иж бүрэн байх, хэмжилт, үнэ зөв байдал гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

#### Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 54.3-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  ДАНХБАЯР



## **2. Аудитын тайлан**

### **2.1 Оршил**

Булган аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг аймгийн Засаг дарга З.Батзориг танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

### **2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага**

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.4-т заасны дагуу Булган аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Булган аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, НББОУС, СТОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн ерөнхийлөн төвлөрүүлэн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, НББОУС, СТОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

### **2.3 Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт**

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэн, шат шатны чанарын хяналт хийж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитыг Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болгож, батлагдсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хэрэгжүүлэв.

## **2.4 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин**

Үйл ажиллагааны эрхэм зорилго нь аймгийн Засаг даргад өндөр мэргэжлийн, цаг үеэ олсон зөвлөгөө өгөх, дэмжлэг үзүүлэх замаар нутгийн захиргааны байгууллагуудын үр дүнтэй хэвийн үйл ажиллагааг хангаж, мэргэшсэн тогтвортой албаар иргэдэд төрийн үйлчилгээ үзүүлэхэд оршино.

Үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Төр, эдийн засаг, нийгмийн бодлогын удирдлагын үйл ажиллагаа

Төсвийн тухай хуулиар аймгийн Засаг дарга Засгийн газрын дараах чиг үүргийг орон нутагт хэрэгжүүлэхээр заасан байна. Үүнд:

- Сургуулийн өмнөх боловсрол
- Ерөнхий боловсрол
- Соёлын үйлчилгээ
- Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ
- Газрын харилцаа, кадастр
- Хүүхдийн хөгжил, хамгааллын үйлчилгээ
- Нийтийн биеийн тамир

Аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны “Хөгжлийн хөтөч” хөтөлбөрийг таван бүлэг, 70 зорилт, 379 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөжээ.

2019 оны жилийн эцсийн байдлаар хэрэгжилтийг тооцон аймгийн ИТХ-аар хэлэлцүүлэн үнэлэлт өгчээ.

Аймгийн Засаг даргын 2016-2020 оны “Хөгжлийн хөтөч” хөтөлбөрийг хэрэгжүүлж зохион байгуулсан ажлын тайлан танилцуулан ИТХ-ын 2019 оны 12 дугаар сарын 05-ний өдрийн 14/02 тогтоолоор хөтөлбөрийн хэрэгжилтийг 86.3 хувиар үнэлжээ.

## **2.5 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ**

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Булган аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох стандарт, журмын дагуу нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг шинэчлэн боловсруулаагүй нь санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх, хууль журам зөрчигдөх зэрэг үр дагавартай байна.

Булган аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн үндсэн үйл ажиллагаа, санхүүгийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдээр 2018 оны жилийн эцэс, 2019 оны эхний хагас жилийн үйл ажиллагааны тайлан, Шилэн дансны 2018 оны жилийн эцсийн 2019 оны

эхний хагас жилийн тайлан, аймгийн 80 жилийн ойн хандивын бүрдүүлэлт, зарцуулалтын байдалд хийсэн шалгалтын дүнг тус тус хэлэлцүүлсэн байна.

Төсвийн Ерөнхийлөн захирагчаар 2019 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө, хяналт шалгалтын график батлуулан ажиллажээ.

Төсвийн ерөнхийлөн захирагчтай байгууллагын үндсэн үйл ажиллагааг хангах зорилгоор гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулан гэрээ байгуулан 89.7 хувьтай дүгнэгдсэн байна.

Тайлант хугацаанд хяналт шалгалтаар 43 актаар 45183.1 мянган төгрөгийн төлбөр тогтоож, 17952.5 мянган төгрөгийг хүү торгуулийн орлого болгосон, 227937,8 мянган төгрөгийн 24 албан шаардлага хүргүүлж албан шаардлагын биелэлт 100 хувьтай байна.

## **2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал**

Аудитын явцад бэлтгэсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 8 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 8 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

## **2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар**

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшнийг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2 хувиар сонгов.

Төлөвлөлтийн шатанд материаллаг байдлын түвшнийг 142912.2 сая төгрөгийн 2 хувь буюу 2858.2 сая төгрөгөөр тогтоов.

Гүйцэтгэлийн үе шатанд төлөвлөлтийн шатанд тогтоосон материаллаг байдлын түвшнийг өөрчлөх шаардлагагүй гэж үзсэн болно.

## **2.8 Аудит хийгдсэн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн тодруулга, аудитын дүн**

### **2.8.1 Мөнгөн хөрөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө**

Булган аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгөнд дараах зүйлсийг бүртгэж тайлагнасан байна. Үүнд:

- Төрийн сангийн харилцахын үлдэгдэл, байгууллага, арилжааны банкнуудад байршдаг зарим төсвийн байгууллагын жижиг мөнгөн сан, харилцах дансны үлдэгдэл, ОНӨҮГ-ууд, төсөл сангийн төгрөгийн харилцах дансны үлдэгдэл
- Кассад байгаа бэлэн мөнгө

Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн мөнгөн хөрөнгийн оны эхний үлдэгдэл 7747.27, жилийн эцэст 6707.59 сая төгрөг болж, 1039.68 сая төгрөгөөр буурсан байна.

**Булган аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

**Мөнгөн хөрөнгийн үлдэгдлийн өсөлт, бууралтыг хүснэгтээр харуулбал**

*Хүснэгт №1. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл /сая төгрөг/*

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Кассад байгаа бэлэн мөнгө	Банканд байгаа бэлэн мөнгө	
				Арилжааны банк	Төрийн сангийн харилцах
<b>Кассад байгаа бэлэн мөнгө</b>	2.84	2.85	2.85		
<b>Төрийн сангийн харилцах</b>	6886.80	6093.48			6093.48
<b>Арилжааны банк</b>	857.63	611.01		611.01	
<b>Замд яваа мөнгө</b>		0.25			
<b>Нийт мөнгөн хөрөнгийн дүн</b>	<b>7747.27</b>	<b>6707.59</b>	<b>2.85</b>	<b>611.01</b>	<b>6093.48</b>
<i>Үүнээс байгууллагын төрлөөр харуулбал:</i>					
<b>Төрийн сан</b>	5035.14	3698.25			3698.25
<b>Төсөвт байгууллага</b>	1828.59	2367.59		0.12	2367.47
<b>ОН-ын өмчит үйлдвэрийн газар</b>	859.53	613.98	2.85	611.14	
<b>Төсөл сангууд</b>	24.01	27.77			27.77
<b>Дүн</b>	<b>7747.27</b>	<b>6707.59</b>	<b>2.85</b>	<b>611.26</b>	<b>6093.48</b>

*Эх сурвалж: Булган аймгийн ТЕЗ-ийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Мөнгөн хөрөнгийн үлдэгдлийн 99.95 хувийг банканд байгаа бэлэн мөнгө, кассад байгаа бэлэн мөнгө 0.04 хувийг, замд яваа мөнгөн хөрөнгө 0.01 хувийг эзэлж байна.

Банканд байршиж буй мөнгөн хөрөнгөөс арилжааны банканд 614.1, төрийн сангийн харилцах дансанд 6093.49 нийт 6704.74 сая төгрөг байна. Үүнээс төрийн сангийн үлдэгдэл 3698.25, төсөвт байгууллагын 2367.47, төсөл сангийн 27.77 сая төгрөгийн үлдэгдэл байна.

Замд яваа мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 0.25 сая төгрөг нь “Булган Мээж” ОНӨК-ий мөнгөн хөрөнгө байна.

Мөнгөн хөрөнгийн үлдэгдлийн 35.30 хувь буюу 2367.59 төсөвт байгууллагын, 55.14 хувь буюу 3698.25 төрийн сангийн, 9.15 хувь буюу 613.98 орон нутгийн өмчит газрын 0.41 хувь буюу 27.77 сая төгрөг нь төсөл сангуудын мөнгөн хөрөнгө эзэлж байна.

Мөнгөн хөрөнгийн үлдэгдлийг сумдаар нь харуулбал

*Хүснэгт №2. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл /сая төгрөг/*

№	Сумын нэр	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	Баян-Агт	60.10	30.24
2	Баяннуур	24.85	65.76
3	Бугат	140.07	120.60
4	Булган	351.09	213.18
5	Булган шууд	5,722.62	4,411.02
6	Бүрэгхангай	359.55	492.40

**Булган аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

7	Гурванбулаг	69.59	157.61
8	Дашинчилэн	149.00	123.35
9	Могод	145.72	174.05
10	Орхон	88.68	126.54
11	Рашаант	47.93	116.52
12	Сайхан	72.31	102.13
13	Сэлэнгэ	95.82	90.94
14	Тэшиг	127.70	42.62
15	Хангал	88.76	105.25
16	Хишиг-Өндөр	113.60	135.72
17	Хутаг-Өндөр	76.95	178.41
18	Хялганат	12.94	21.24
	<b>Нийт</b>	<b>7,747.27</b>	<b>6,707.59</b>

Төрийн сан дахь нийт 6707.59 сая төгрөг үлдэгдэл нь аймгийн төсвийн ерөнхий орлогын дансанд 3090.75, сумдын төсвийн ерөнхий орлогын 605.06, сум хөгжүүлэх сангийн 797.1, аймгийн ОНХС 98.56, сумын ОНХС 423.84, замын сангийн 140.05, мал хамгаалах сан 49.29, байгаль хамгаалах сан 15.84, гамшгаас хамгаалах сан 24.11, ОНХО дансанд 396.55 сая төгрөгийн тус тус үлдэгдэлтэй байна.

Орон нутгийн өмчит үйлдвэрийн газрын мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 613.98 сая төгрөгийн 95.7 хувь буюу 587.43 сая төгрөг нь “Булган Мээж” ХХК-ий үлдэгдэл байна.

### **Банкин дахь харилцах дансны талаар**

Арилжааны банканд нийт 611.01 сая төгрөг байршиж байгаагаас ЭЭС-гууд 7.15 сая төгрөг, “Булган Мээж” ХХК 587.43, аймгийн Нөөцийн газар 0.32, Илчит-Хутаг ОНӨААТҮГ 16.04 сая төгрөгийн харилцах дансны үлдэгдэлтэй тайлагнажээ.

#### **Аудитын илрүүлэлт:**

- *Сахилгын шийтгэлтэй ажилтанд үр дүнгийн урамшуулал олгосон/ Булган сумын 3-р сургууль 0.3, Бугат сумын ЗДТГ 0.5, Булган сумын ЗДТГ 0.3, Булган сумын ТҮА 0.2, Орхон сумын ЗДТГ 0.1, Сайхан сумын ЗДТГ 0.5, Хутаг-Өндөр сумын Цэцэрлэг 5.1, ХГБЗХГ 0.4, Баян-агт сумын Цэцэрлэг 0.4 сая төгрөгийг тус тус олгосон,*
- *Сургуулийн захирал, Цэцэрлэгийн эрхлэгч нарт аймаг, сумын Засаг даргын захирамжаар үр дүнгийн урамшуулал давхардуулан олгосон /Булган сумын 1 дүгээр сургууль 0.9, 2 дугаар сургууль 0.4, спортын дунд сургууль дугаар сургууль 0.4, Гурванбулаг сумын сургууль 0.3, Могод сумын сургууль 0.3, Орхон сумын сургууль 0.4, Рашаант сумын сургууль 0.9, Тэшиг сумын сургууль 0.9, Хангал сумын сургууль 0.3, Бугат сумын сургууль 0.9, Баяннуур сумын сургууль 0.9 сая төгрөгийг сургуулиуд байна. Булган сумын 1, 2,3, 4, 5, 6, цэцэрлэгүүд 2.6, Баян-Агт 0.8, Бугат 0.4, Баяннуур 0.8, Бүрээхангай 0.4, Гурванбулаг 0.4, Орхон 0.4, Рашаант 0.8, Сайхан 0.8, Сэлэнгэ 0.3, Тэшиг 0.8, Хишиг-Өндөр 1.1, Хутаг-Өндөр 0.8, Хялганат 0.4 зэрэг сумдын цэцэрлэгүүд олгосон,.*
- *Өрхийн эмнэлгийн даргын Б/02 дугаар тушаалаар удаан жилийн нэмэгдлийг дарга Т.Должинсүрэн, сувилагч Х.Ургамал, А.Буянхишиг нарт нийт 1.8 сая төгрөгийг олгосон,*
- *Өрхийн эрүүл мэндийн төвийн даргаар ажиллаж байсан Т.Должинсүрэнд 2019 оны 08 дугаар сарын 12-ны өдрөөс ажлаас чөлөөлөгдсөн байхад 12 сард тэтгэмж бодож олгосон,*

**Булган аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

- Нягтлан бодогч Б.Туяад удаан жилийн нэмээдэл, өрхийн эрүүл мэндийн төвийн дарга, эмчийн ажлыг хавсарч эмчийн цалингийн 20 хувиар 2-6 сард цалин тус тус олгосон,
- Дагалдах мөнгөн шагнал олгосон байна. /ӨЭМТ 0.1, Аймгийн ЗДТГ 1.0 /
- Анхан шатны баримт материал дутуу гүйлгээ хийсэн /Эмийн цэцэглэн ӨЭМТ 0.3, Илчит Хутаг ОНӨААТҮГ 0.3, Гурванбулаг сумын сургууль 2.1, Могод сумын сургууль 0.3, Тэшиг сумын сургууль 0.6, Баяннуур сумын сургууль 0.5, БТСГ 0.2 сая төгрөг/
- Тайлант хугацаанд хувь хүний сугалаатай баримтаар худалдан авч бүртгэлд тусгасан. /Тэшиг-Ус ОНӨААТҮГ, Булган Мээж ОНӨК 1.7, /
- Булган сумын ИТХ гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардлаас Тэшиг сумын ИТХ-ын тэргүүлэгч, төлөөлөгчид ирэхэд хүндэтгэл үзүүлэх зардалд 0.4 сая төгрөгийг зориулалт бус зардалд зарцуулсан,
- Аймгийн ЗДТГ нь Засаг даргын 2013 оны А/11 дүгээр захирамжаар баталсан байгууллагын дотоод журмын 6.2.1 дэх заалтыг зөрчин 4 албан хаагчид 4.9 сая төгрөгийн тэтгэмж олгосон,
- Цалингийн зардлаас ахмадын санд зориулалт бус зардал гаргасан / Булган сумын 1,3,6,7 Баяннуур Гурванбулаг зэрэг цэцэрлэгүүд, Орхон сумын сургууль, Рашаант сумын ЗДТГ, / байна.
- Малын гоц халдварт шүлхий өвчний үед ажилласан төрийн албан хаагчид цалингийн зардлаас урамшуулал олгосон / Рашаант сумын цэцэрлэг 2.6, ЗДТГ 6.8, ИТХ 1.5, Соёлын төв 0.9, Гурванбулаг сумын цэцэрлэг 4.2 сая төгрөгийг олгосон байна.
- Байгууллагын мөнгөн хөрөнгийн зарцуулалтын журамд заасан хязгаараас давсан дүнгээр гүйлгээ хийсэн / Орхон сумын ЗДТГ 5.5 сая төгрөг

**2.8.2 Авлага**

Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд нийт авлагын эхний үлдэгдэл 5630.28 сая төгрөг оны эцэст 5517.57 сая төгрөгөөр тайлагнаж, өмнөх оноос 112.71 сая төгрөгөөр буурсан байна.

**Нийт авлагын үлдэгдлийг бүтэц, ангиллаар нь харуулбал**

*Хүснэгт №3. Авлагын үлдэгдэл /сая төгрөг/*

Авлагын ангилал	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Зөрүү	Хувиар
Ажилчидтай холбоотой авлага	5.49	10.78	5.29	0.20
Төлбөртэй үйлчилгээний авлага	9.25	6.93	-2.32	0.13
Татаас санхүүжилтийн авлага	15.25	5.68	-9.57	0.10
Зээлийн хүүгийн авлага	4.79	34.06	29.27	0.62
Дансны авлага /ТӨҮГ/	0.37	0.57	0.2	0.01
Татвар НДШ-ын авлага /ТӨҮГ/	2.59	4.47	1.88	0.08
Байгууллагаас авах авлага	1092.97	870.85	-222.12	15.78
Хувь хүнээс авах авлага	4317.74	4402.4	84.66	79.79
Засгийн газрын байгууллага, бусад шатны төсөвт олгосон	181.83	181.83	0	3.30
<b>Нийт дүн</b>	<b>5630.28</b>	<b>5517.57</b>	<b>-112.71</b>	<b>100</b>
<b>Үүнээс, байгууллагын төрлөөр</b>				
Төсөвт байгууллага	5142.82	5026.99	-115.83	91.11
Төсөл/сан	50.81	48.02	-2.79	0.87

**Булган аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

<b>Төрийн сан</b>	212.77	214.42	1.65	3.89
<b>ОНӨГ</b>	223.88	228.14	4.26	4.13
<b>Дүн</b>	<b>5630.28</b>	<b>5517.57</b>	<b>-112.71</b>	<b>100.00</b>

*Эх сурвалж: Булган аймгийн ТЕЗ-ийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Нийт авлагын үлдэгдлээс нэмэлт санхүүжилтийн данснаас төвлөрүүлсэн 98.5 сая төгрөгийн авлага үүсгэснийг устгах бичилт хийсэн байна.

Авлагын дансны үлдэгдлийг байгууллагын төрлөөр авч үзвэл нийт авлагын 91.11 хувь нь төсөвт байгууллагын, 3.89 хувь нь төрийн сангийн, 4.13 хувь нь ОНӨГ-ын, 0.87 хувь нь төсөл сангийн авлага байна.

Авлагын үлдэгдэлд олон жилийн насжилттай 212.8 сая төгрөгийн дараах авлагууд байна. Үүнд:

- 1997 онд үүссэн “Баялаг” компанитай холбоотой аймгийн нөөц барааны үлдэгдэл үнэ 1198.6, ОК-ийн шугамаар ирсэн тэжээлийн хивгийн үнэ 1171.0 мянган төгрөгийн авлага, одоогоор уг компани байхгүй эзэн холбогдогчгүй,
- 1997 онд үүссэн Спиртийн үйлдвэрт олгосон зээлийн үлдэгдэл 11.4 сая төгрөгийн авлага,
- 1998 онд үүссэн “Чин хоршоо”-нд бөөний худалдаа дэмжих зорилгоор олгосон 1.6 сая төгрөгийн зээлийн авлага,
- 1999 онд үүссэн “ХОТШ” банктай холбоотой 0.5 сая төгрөгийн авлага
- 1999 онд үүссэн “Царс-Импекс” ХХК-наас татварын өрөнд авсан нүүрсийг дамжуулж өгөхдөө дутуу өгсөн 11.4 сая төгрөгийн авлага,
- 1999 онд үүссэн “СОНУ” ХХК-тай холбоотой, улсын төсвийн хөрөнгө оруулалтаар өгсөн хөрөнгөнөөс хийгдээгүй ажлын санхүүжилт гэж аймгийн татааснаас суутгаж авсан 12.28 сая төгрөгийн авлага,
- 2008 онд үүссэн “Атрын III” аяны хүрээнд олгогдсон 137.39 сая төгрөгийн авлага,
- Өвсний авлага Баяннуур сум 4.79, Бугат 2.08, Сэлэнгэ 9.45, Хишиг-өндөр 2.4, Хутаг-Өндөр сум 12.2 нийт 30.94 сая төгрөгийн авлага сумдын төрийн сангуудад үүссэн байна.

**Сум хөгжүүлэх сангийн авлага:**

Төсөл сангийн шугамаар иргэдэд олгож байгаа, эргэн төлөгдөх нөхцөлөөр жижиг дунд үйлдвэрлэл дэмжих зорилгоор СХС-гаас олгосон зээлтэй холбоотой үүссэн авлагын эхний үлдэгдэл 4058.3 сая төгрөг 2019 онд 149 иргэнд 1015.5 сая төгрөгийг зээл олгож авлагын эцсийн үлдэгдэл 4095.3 сая төгрөг үүнээс 1883.1 сая төгрөг нь хугацаа хэтрэлттэй байгаа нь СХС-гийн хөрөнгийн эргэцийг удаашруулж, үр өгөөжийг бууруулсан байна.

Сум хөгжүүлэх сангийн зээлийн үлдэгдлийг сумдаар нь харуулбал:

*Хүснэгт №4. Сум хөгжүүлэх сангийн авлагын үлдэгдэл /сая төгрөг/*

№	Сум, Нэрс	Нийт иргэдийн тоо	Нийт зээлийн үлдэгдэл	Хугацаа хэтэрсэн зээлтэй иргэдийн тоо	Хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэл	Хэвийн зээлдэгчийн тоо	Хэвийн зээлийн үлдэгдэл
1	Баян-Агт сум	55	218.6	13	85.8	42	132.75
2	Баяннуур сум	48	169.4	26	83.4	22	85.95
3	Бугат сум	42	209.8	24	112.3	18	97.55

**Булган аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

4	Булган сум	125	903.8	46	416.6	79	487.22
5	Бүрэгхангай сум	34	185.7	23	88.2	11	97.53
6	Гурванбулаг сум	82	151.8	60	81.6	22	70.20
7	Дашинчилэн сум	49	185.9	12	33.8	37	152.15
8	Могод сум	29	130.9	13	86.0	16	44.91
9	Орхон сум	92	322.5	52	148.7	40	173.86
10	Рашаант сум	67	212.6	30	95.3	37	117.33
11	Сайхан сум	84	304.2	60	148.4	24	155.82
12	Сэлэнгэ сум	44	213.1	23	101.4	21	111.70
13	Тэшиг сум	82	249.8	66	183.8	16	65.99
14	Хангал сум	83	288.2	31	90.7	52	197.49
15	Хишиг-Өндөр сум	29	146.3	9	19.8	20	126.47
16	Хутаг-Өндөр сум	66	202.5	38	107.2	28	95.29
	Нийт дүн	1011	4095.3	526	1883.1	485	2212.2

Сум хөгжүүлэх сангийн зээлийн авлагыг бууруулах талаар өмнөх онд зөвлөмжийг хүргүүлснээр хугацаа хэтрэлттэй зээлүүдийг хуулийн байгууллагад шилжүүлж байгаа бөгөөд ажлыг эрчимжүүлэх шаардлагатай байна.

Авлагыг сумдаар нь авч үзвэл:

*Хүснэгт № 5 Сумдын авлагын /сая төгрөг/*

Байгууллагын нэрс	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт, бууралт
Баян-Агт	299.34	268.85	-30.49
Баяннуур	237.17	219.76	-17.41
Бугат	218.91	260.33	41.42
Булган	979.19	1,008.62	29.43
Булган шууд	906.35	870.75	-35.60
Бүрэгхангай	270.20	214.87	-55.33
Гурванбулаг	224.26	152.03	-72.23
Дашинчилэн	139.93	185.92	45.99
Могод	136.00	132.97	-3.03
Орхон	376.42	342.54	-33.88
Рашаант	255.08	229.84	-25.24
Сайхан	337.36	325.04	-12.32
Сэлэнгэ	197.95	260.66	62.71
Тэшиг	217.69	288.50	70.81
Хангал	275.93	304.84	28.91
Хишиг-Өндөр	197.32	167.01	-30.30
Хутаг-Өндөр	335.45	265.02	-70.43
Хялганат	25.74	20.01	-5.73
<b>Нийт</b>	<b>5,630.29</b>	<b>5,517.57</b>	<b>-112.72</b>

Авлагыг Булган сум 29.43, Бугат сум 41.42, Дашинчилэн сум 45.99, Сэлэнгэ сум 62.71, Тэшиг сум 70.81 Хангал сум 28.91 сая төгрөгөөр авлагыг нэмэгдүүлсэн байна.

Сумдын авлагыг байгууллагын төрлөөр нь үзвэл ОНХС 69.4, сум хөгжүүлэх сан 40956.3, ЖДҮД сан 139.91, төсөвт байгууллага 88.31, ОНӨ газрууд 42.36 сая төгрөг зэрэг авлагууд байна.

**Аудитын илрүүлэлт:**

- Аймгийн ЗДТГ-ын орон сууц худалдсанаас 2012 онд үүссэн 8 жилийн насжилттай хүмүүсээс авах авлагын 25.3 төгрөгийг барагдуулаагүй,
- Санхүүгийн тайлан гарахад тооцоо нийлж баталгаажуулаагүйгээс авлага нэмэгдсэн нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх." гэсэн заалтыг зөрчсөн /Булган сумын соёлын төв ХХОАТ 0.9, Сэлэнгэ сумын сургууль ХХОАТ 4.0, Тэшиг сумын сургууль ХХОАТ 5.8 сая төгрөг/
- Тайлант онд үүссэн авлагыг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй. /Сайхан сумын ОНХС 0.4, Баяннуур сумын ЗДТГ 0.3, Хялганат тосгоны ЗАА 0.2, Тэшиг сумын ЗДТГ 7.8 сая төгрөг/
- Орон нутгийн халамжийн сан өмнөх оны аудитаар өгсөн зөвлөмж болох авлагын үлдэгдлийг барагдуулаагүй оны эцэст 1365.6 мянган төгрөгийн авлагатай,
- Аймгийн байгаль хамгаалах сангийн санхүүгийн тайлангаар 242.0 сая төгрөгийн 9 сум, Ленда ХХК-тай холбоотой нөхөн сэргээлт, ойжуулалтын авлагыг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй
- Төрийн сангийн нийт авлага 212.7 сая төгрөгийн үлдэгдэлтэй үүнээс 1996-2002 онуудад үүссэн хүнс, өвс тэжээл, зээл зэрэг 75.3, 2008 онд "Атрын III" аяны хүрээнд иргэдэд эргэн төлөгдөх нөхцөлөөр олгосон зээлийн авлага 137.39 сая төгрөгийн авлагыг барагдуулах талаар өмнөх оны СТА-аар өгөгдсөн боловч тодорхой ажил зохион байгуулаагүй, авлага барагдуулах арга хэмжээ аваагүй.

**2.8.3 Урьдчилгаа**

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлангаар урьдчилгаа ~~Мөнгөн хөрөнгийн оны эхний үлдэгдэл 4,320.6 тэрбум, эцсийн үлдэгдэл 4,625.7 тэрбум төгрөг болж, 305.1 тэрбум төгрөгөөр өссөн байна.~~ данс эхний үлдэгдэлгүй Хутаг-Өндөр сумын Илчит-Хутаг ОНӨААТҮГ-ын урьдчилж гаргасан зардал 14.08 сая төгрөг бүртгэж эцсийн үлдэгдэл 14.08 сая төгрөг байна.

**Хүснэгт № 6 Урьдчилгаа дансны үлдэгдэл /сая төгрөг/**

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Урьдчилж гарсан зардал	0	14.08	14.08
Бараа материал бэлтгэх			
Урьдчилгаа			
урьдчилгаа			
Цалингийн урьдчилгаа			
Томилолтын урьдчилгаа			
<b>Дүн</b>	<b>0</b>	<b>14.08</b>	<b>14.08</b>
<i>Үүнээс, байгууллагын төрлөөр</i>			
Төсөвт байгууллага			
Төсөл/ сан			
Төрийн сан			
ТӨҮГ болон ОНӨҮГ		<b>14.08</b>	<b>14.08</b>

<b>Дүн</b>	<b>0</b>	<b>14.08</b>	<b>14.08</b>
------------	----------	--------------	--------------

Эх сурвалж: Булган аймгийн ТЕЗ-ийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Урьдчилгаа дансны үлдэгдэлд 14.08 сая төгрөг нь “Илчит-Хутаг” ОНӨААТҮГ-ын нүүрс тээврийн зардалтай холбоотой төлбөр байна.

#### 2.8.4 БАРАА МАТЕРИАЛ

ТЕЗ-ийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд нийт бараа материалын эхний үлдэгдэл 6317.85 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 7019.35 сая төгрөгөөр тайлагнагдаж, тайлант онд 701.5 сая төгрөгөөр өссөн байна.

Бараа материалын үлдэгдлийг нэр төрлөөр нь харуулбал:

Хүснэгт № 7 Бараа материалын үлдэгдэл /сая төгрөг/

Материалын төрөл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт, бууралт	Хувь
Тусгай зориулалтын материал	680.55	833.75	153.2	11.88
Эм боох материал	267.43	432.41	164.98	6.16
Бэлэн бүтээгдэхүүн	23.29	35.33	12.04	0.50
Бичиг хэргийн материал	121	180.01	59.01	2.56
Аж ахуйн материал	2470.15	2667.13	196.98	38.00
Сэлбэг хэрэгсэл	134.78	128.36	-6.42	1.83
Түлш, шатах тослох материал	163	152.65	-10.35	2.17
Барилгын засварын материал	86.87	122.51	35.64	1.75
Хүнсний материал	294.73	401.15	106.42	5.71
Бусад хангамжийн материал	1695.49	1,721.31	25.82	24.52
Мал амьтад	380.52	344.74	-35.78	4.91
Нөөцийн бараа				0.00
<b>ДҮН</b>	<b>6317.85</b>	<b>7019.35</b>	<b>701.5</b>	<b>100</b>
Үүнээс, байгууллагын төрлөөр				
Төсөвт байгууллага	5448.82	6161.82	713	
Төсөл сан	0.93	0.42	-0.51	
ОНӨҮГ	868.1	857.11	-10.99	
<b>ДҮН</b>	<b>6317.85</b>	<b>7019.35</b>	<b>701.5</b>	

Эх сурвалж: ТЕЗ-ийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд төсвийн хөрөнгөөр 7873.53, хандив тусламжаар 152.95, шилжүүлгээр болон бүтцийн өөрчлөлтөөр 200.72, бусад эх үүсвэрээс 328.72 сая төгрөгийн бараа материалыг авч, тайлант онд 7349.52, сая төгрөгийн хөрөнгийг зарцуулж, шилжүүлгээр болон бүтцийн өөрчлөлтөөр 1594.43, бусад болон акталж устгасан 345.48 сая төгрөгийн хөрөнгө хасагдаж хөрөнгийн үлдэгдэл өмнөх оноос 701.54 сая төгрөгөөр өссөн үзүүлэлттэй байна.

Тусгай зориулалтын материал өмнөх оноос 153.2 сая төгрөгөөр, эм боох материал 153.2 бэлэн бүтээгдэхүүн 12.04, бичиг хэргийн материал 59.01, аж ахуйн материал 196.98, барилгын материал 35.64, хүнсний материал 106.42, бусад хангамжийн материал 25.82 сая төгрөгөөр тус тус өссөн, харин мал амьтад нь төсвийн байгууллагын бараа материалын бүрэлдэхүүнд орж байгаа бөгөөд өмнөх

**Булган аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

оноос 35.78 сая төгрөгөөр буурчээ. Нийт бараа материалын үлдэгдлийн 87.78 хувь буюу 6161.82 сая төгрөг нь төсөвт байгууллагын, 0.01 хувь буюу 0.93 сая төгрөг нь төсөл сангийн, 12.21 хувь 857.11 сая төгрөг нь ОНӨҮГ газрын бараа материал тус тус эзэлж байна.

**Аудитын илрүүлэлт:**

- *Бараа материалын тооллого, тооцоо хийгээгүй, чанаргүй хийсэн /Цоожид ӨЭМТ 19.2 тооллого хийгээгүй, Эмийн цэцэглэн ӨЭМТ тооллого хийгээгүй, Бүрээхангай сумын ЗДТГ 0.1 сая төгрөгийн сэлбэг хэрэгслийн, Аймгийн ЗДТГ чанаргүй хийсэн,/*
- *Дутуур байрны хүүхдэд олгох нэг өдрийн хоолны норматив зардлыг хэтрүүлсэн /Тэшиг сумын сургууль 0.9, Хишиг-Өндөр сумын сургууль 3.9, Баян-Агт сумын сургууль 0.5, Булган сумын 1 дүгээр сургууль 11.8, Бүрээхангай сумын сургууль 0.3, Гурванбулаг сумын сургууль 0.3, Дашинчилэн сумын сургууль 1.2, Могод сумын сургууль 0.3,*
- *Үдийн цайны нэг хүүхэд олгох норматив зардлыг хэтрүүлсэн / Тэшиг сумын сургууль 0.5, Хишиг-Өндөр сумын сургууль 1.3, Бүрээхангай сумын 0.1, Гурванбулаг сумын сургууль 0.3,*
- *Сангийн сайдын 2017 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн 347 тоот тушаалын дагуу батлагдсан маягтын дагуу няравын тайлан гаргаагүй /ГХБХБГ шатахууны тайлан 7.4, Бүрээхангай сумын ЗДТГ шатахууны тайлан 4.8, Сэлэнгэ сумын ЗДТГ бараа материалын тайлан, тооцоо бодсон акт байхгүй, данс тус бүрээр бүртгэлд стандартын дагуу бүртгэж ангилаагүй 159.8 сая төгрөг/*
- *Анхан шатны баримт материал дутуу шатахуун зарцуулсан, / Эрдмийн өргөө цогцолбор сургууль 1.4, Гурванбулаг сумын сургууль 3.3, Хишиг-Өндөр сумын сургууль 1.7 сая төгрөг/*
- *Сургууль, цэцэрлэгүүд хүнсний материал нийлүүлэх тендер сонгон шалгаруулалт явуулаагүй, / Орхон сумын сургууль, Булган сумын 1,2,3,4,6,7 дугаар цэцэрлэгүүд, Бүрээхангай, Гурванбулаг, Орхон, Тэшиг сум, Хялганат тосгоны цэцэрлэгүүд нийт 371.0 сая төгрөг/*
- *Номын сан няравын тайлангийн анхан шатны баримтын бүрдэл дутуу, тээвэр шатахууны зардлаас 0.2 сая төгрөг гаргасан боловч нярав шатахууны тайлан гаргаагүй замын хуудсаар зарцуулсан,*
- *ГХБХБГ нь тээвэр шатахууны зардлаас 2.1 сая төгрөгийг тооцооны дансаар дамжуулаагүй шууд зардалд бичсэн, өмч хамгаалах зөвлөлийн шийдвэргүйгээр 1.3 сая төгрөгийг сэлбэг хэрэгслийн зардалд зарцуулсан,*

**2.8.5 Үндсэн хөрөнгө**

Аймгийн ТЕЗ-ийн 2019 оны санхүүгийн нэгдсэн тайланд үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл 162529.83 сая төгрөгөөр, эцсийн үлдэгдэл 168097.20 сая төгрөгөөр тайлагнагдаж тайлант онд 5567.37 сая төгрөгөөр өссөн үзүүлэлттэй байна.

Үндсэн хөрөнгийг нэр төрлөөр нь харуулбал:

**Хүснэгт № 8 Үндсэн хөрөнгийн үлдэгдэл /сая төгрөг/**

Ангилал	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт+	
			Бууралт-	
			тоогоор	Хувиар
Барилга байгууламж	111,798.88	115,683.70	3,884.82	68.82
Тээврийн хэрэгсэл	6,729.77	7,131.27	401.50	4.24
Машин тоног төхөөрөмж	11,977.31	12,910.28	932.97	7.68

**Булган аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

Тавилга эд хогшил	5,409.08	5,945.35	536.27	3.54
Зам гүүрний байгууламж	4,704.78	5,213.74	508.96	3.10
Батлан хамгаалахын тоног төхөөрөмж	0.39	0.39	0.00	0.00
Түүх соёлын дурсгалт зүйл	1,116.90	1,119.01	2.11	0.67
Дуусаагүй барилга байгууламж	5,506.71	2,155.11	-3,351.60	1.28
Номын фонд	761.02	826.11	65.09	0.49
Бусад үндсэн хөрөнгө	9,255.35	11,376.03	2,120.68	6.77
Программ хангамж	155.24	159.51	4.27	0.09
Бусад биет бус хөрөнгө	5114.4	5,576.70	462.30	3.32
<b>Нийт дүн</b>	<b>162,529.83</b>	<b>168,097.20</b>	<b>5,567.37</b>	<b>100.00</b>
<b>Байгууллагын ангиллаар</b>				
<b>Төсөвт байгууллага</b>	148810.49	155761.05	6,951	92.66
<b>ОНӨҮГ</b>	13719	12336	-1,383	7.34
<b>ДҮН</b>	<b>162529.83</b>	<b>168097.20</b>	<b>5567.37</b>	<b>100</b>

Эх сурвалж: ТЕЗ-ийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Нийт үндсэн хөрөнгийн 99.9 хувийг биет хөрөнгө үлдэх 0.1 хувийг биет бус хөрөнгө эзэлж байна. Өмнөх оноос барилга байгууламж 3884.82, тээврийн хэрэгсэл 401.5, машин тоног төхөөрөмж 932.97, тавилга эд хогшил 536.27, зам гүүрний байгууламж 508.96, номын 65.09, бусад үндсэн хөрөнгө 2120.68 сая төгрөгөөр тус тус өссөн үзүүлэлттэй байна.

Үндсэн хөрөнгийн 92.66 хувийг төсөвт байгууллага, 7.34 хувийг ОНӨҮГ-ын тус тус эзэлж байна.

Тайлант хугацаанд үндсэн хөрөнгө 11748.9 сая төгрөгөөр нэмэгдсэн ба үүний дотор төсвийн хөрөнгөөр 1991.1, хандиваар 757.35, шилжүүлж авсан 4008.76, бүтцийн өөрчлөлтөөр 17.08, бусад 4688.9, дахин үнэлгээний нэмэгдэл 285.63 сая төгрөгөөр тус тус нэмэгдсэн байна. Харин үндсэн хөрөнгө 6181.55 сая төгрөгөөр хасагдсаны дотор худалдсан 177.89, акталсан 2386.79, шилжүүлсэн 3587.18, бусад 29.69 сая төгрөг тус тус хасагдсан байна.

Дуусаагүй барилга дансанд Орхон сумын ЗДТГ 174.5, Тэшиг сумын сургуулийн 550.0 сургуулийн барилга, Хишиг-Өндөр сумын сургуулийн 59.0, Уньт бага сургуулийн 23.9, Соёлын төвийн 2.3, Булган сумын 2 дугаар цэцэрлэгийн 1340.2 сая төгрөгийн барилгыг улсын комисс хүлээж аваагүй нийт 2155.1 сая төгрөгийн хөрөнгө бүртгэлтэй байна.

**Аудитын илрүүлэлт:**

- Хөрөнгө бэлтгэх зөвшөөрөлгүйгээр бусдаар гүйцэтгүүлэх зардлаас тоног төхөөрөмж, тавилга эд хогшил худалдаж авсан. /ГБХЗХГ 2.9, Булган сумын ЗДТГ 0.6 сая төгрөг
- Тогтмол зардлаас хөрөнгө бэлтгэсэн /Булган сумын 1-р цэцэрлэг 1.1 сая төгрөг/
- Үндсэн хөрөнгийн тооллогын анхан шатны баримт материал дутуу, тооллогыг чанаргүй хийсэн /Аймгийн ЗДТГ, Тэшиг сумын ЗДТГ/
- Булган сумын ЗДТГ бараа материалын дансны тусгай зориулалтын материалын дансанд ширээ, сандал зэрэг 9 нэр төрлийн 13935920 төгрөгийн

үндсэн хөрөнгө бүртгэлтэй байгаа нь НББОУС-16-д “Үндсэн хөрөнгө гэж дараах шалгуурыг хангасан хөрөнгийг хэлнэ а/ үйлдвэрлэл, борлуулалт, үйлчилгээ, түрээс эсвэл удирдлагын хэрэгцээнд ашиглаж байгаа б/ нэгээс дээш тайлант хугацаанд ашиглагдах” хөрөнгийг хэлнэ гэж заасны хэрэгжүүлж ажиллаагүй байна.

- Булган сумын ЗДТГ: Аймгийн Засаг даргын 2019 оны 10 дугаар сарын 21-ний өдрийн А/502 дугаар захирамжаар хог тээврийн машин худалдан авах 43000000 төгрөгийг Булган сумын Засаг даргад эрх шилжүүлсэн, тендерт 2 компани оролцож шаардлагад нийцсэн тендер ирээгүй тул хуулийн дагуу арга хэмжээ авахыг үнэлгээний хороо зөвлөж, сумын Засаг дарга "Гэрэлт-моторс" ХХК-тай шууд гэрээ байгуулсан нь ТБОНӨХБАУХАТХ-ийн 33 дугаар зүйл 33.2.2 дэх" техникийн болон бусад нөхцөл шаардлагыг хангаж байгаа хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид энэ хуулийн 29.1-д заасны дагуу гэрээ байгуулах эрх олгох, 29 дүгээр зүйлийн 29.1 дэх " Захиалагч энэ хуулийн 27 дугаар зүйлд заасан шаардлага хангасан, 28 дугаар зүйлд зааснаар 'хамгийн сайн' үнэлэгдсэн тендер ирүүлсэн оролцогчид гэрээ байгуулах эрх олгохоор шийдвэрлэж, энэ тухай түүнд болон бусад тендерт оролцогч бүрд шалгараагүй үндэслэлийн хамт нэгэн зэрэг бичгээр мэдэгдэнэ" гэсэн заалтуудыг зөрчсөн байна.
- Аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөнөөс Эрдмийн өргөө цогцолбор сургуульд тоног төхөөрөмж техник хэрэгсэл худалдаж авахад дэмжлэг үзүүлэхэд 5.0, Прокурорын газарт авто машин худалдан авахад 10.0, Хутаг-Өндөр сумын "Гуртын гүүр"-ийн мал эмнэлэг, хорио цээрийн хяналтын хэсгийн албаны хэрэгцээнд авто машин авахад 10.0, Цагдаагийн газар авто машин авахад 5.0 төгрөгийг тус тус зарцуулсан,
- Булган Мээж ОНӨК нь НББ-ийн бодлогын баримт бичиг "Үндсэн хөрөнгийн бүртгэлийн бодлого"-д элэгдэл тооцох хугацааны зөрүү гаргахаар бол компани хойшлогдсон татварын хөрөнгө, өр төлбөрийн дүнг тооцож бүртгэнэ гэж заасан боловч бүртгэдэггүй,
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 72.4.5 дахь заалтыг хэрэгжүүлэн ажиллаагүй, данс бүртгэлд байгаа ашиглалтгүй үндсэн хөрөнгийн ашиглалтыг сайжруулах, данс бүртгэлээс хасах, хөрөнгийн хөдөлгөөн өөрчлөлт хийх ажлыг зохион байгуулаагүй, төсөл хөтөлбөрөөр хэрэгжсэн ажлуудын хөрөнгийг дутуу бүртгэсэн зөрчил илэрсэн. /ОНӨГ/

### 2.8.6 Өр төлбөр

Орон нутгийн ТЕЗ-ийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд нийт өр төлбөрийн эхний үлдэгдэл 4337.91 сая төгрөг байснаас тайланд онд 139.41 сая төгрөгөөр буурч 4198.5 сая төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнагджээ.

Нийт өр төлбөрийн үлдэгдлийг бүтэц, байгууллагын төрлөөр харуулбал:

Хүснэгт № 9 Өр төлбөрийн үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт/+/ бууралт /-/	Дүнд эзлэх хувь
<b>Богино хугацаат өр төлбөр</b>	<b>792.63</b>	<b>662.39</b>	<b>-130.24</b>	<b>15.78</b>
Арилжааны банк	0.7	38.08	37.38	0.91
Ажилчидтай холбогдсон өглөг	30.91	53.22	22.31	1.27
Бараа үйлчилгээний зардлын өглөг	70.4	19.54	-50.86	0.47
Татаас санхүүжилт, шилжүүлэг өглөг		1.66	1.66	0.04
Байгууллагад төлөх өглөг	539.22	499.64	-39.58	11.90

**Булган аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

Хувь хүмүүст төлөх өглөг	115.99	3.46	-112.53	0.08
Татварын өглөг	30.07	43.16	13.09	1.03
НДШ-ийн өглөг /ТӨҮГ/	3.29		-3.29	0.00
Дансны өглөг	2	3.63	1.63	0.09
Төрийн өмчит үйлдвэр, аж ахуйн газар	0.045		-0.045	0.00
<b>Урт хугацаат өр төлбөр</b>	<b>3545.28</b>	<b>3536.11</b>	<b>-9.17</b>	<b>84.22</b>
Төрийн өмчит аж ахуйн нэгжүүдийн зээл	3522.74	3522.74	0	83.90
Арилжааны банк	22.36	12.74	-9.62	0.30
Нөөц /өр төлбөр/ ТӨҮГ/	0.18	0.63	0.45	0.02
<b>Нийт</b>	<b>4337.91</b>	<b>4198.5</b>	<b>-139.41</b>	<b>100</b>
<b>Үүнээс, байгууллагын төрлөөр</b>				
Төсөвт байгууллага	230.98	146.11	-84.87	22.05
Төсөл сан				
Төрийн сан	221.47	101.21	-120.26	15.28
ОНӨҮГ	340.18	415.08	74.9	62.67
	792.63	662.39	130.23	100

Эх сурвалж: ТЕЗ-ийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Нийт өглөгийн үлдэгдлээс нэмэлт санхүүжилтийн данснаас төвлөрүүлсэн 98.5 сая төгрөгийн өглөг үүсгэснийг устгах бичилт хийсэн байна.

Нийт өр төлбөрийн 84.22 хувь буюу 3536.11 сая төгрөгийг урт хугацаат өр төлбөр, 15.78 хувь буюу 662.39 сая төгрөгийг богино хугацаат өр төлбөр эзэлж байна.

Сумдын өр төлбөрийн үлдэгдэл тайлант оны эхэнд 317.48 сая төгрөг байснаас 51.58 сая төгрөгөөр буурч, 265.62 сая төгрөгийн үлдэгдэлтэй болсон нь нийт өр төлбөрийн 6.32 хувийг эзэлж байна.

**Өр төлбөрийг сумаар авч үзвэл :**

Хүснэгт № 10 Сумдын өр төлбөрийн үлдэгдэл /сая төгрөг/

Байгууллагын нэрс	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт +/- бууралт +/-
Баян-Агт	4.90	4.15	-0.75
Баяннуур	10.20	6.29	-3.91
Бугат	15.97	21.91	5.94
Булган	25.44	8.11	-17.33
Бүрэгхангай	4.45	2.69	-1.75
Гурванбулаг	4.29	0.5084	-3.78
Дашинчилэн	13.12	11.50	-1.62
Могод	4.46	4.46	0.00
Орхон	22.85	13.65	-9.20
Рашаант	0	3.53	3.53
Сайхан	0.5398	1.12	0.58
Сэлэнгэ	18.27	25.38	7.12
Тэшиг	157.75	141.93	-15.82

**Булган аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

Хангал	0.0401	0	-0.04
Хишиг-Өндөр	3.84	4.51	0.67
Хутаг-Өндөр	31.38	15.69	-15.69
Хялганат	0	0.2012	0.20
<b>Нийт дүн</b>	317.48	265.62	-51.85

Эх сурвалж: ТЕЗ-ийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Хүснэгтээс үзэхэд тайлант онд Рашаант сум 3.53, Бугат 5.94, Сэлэнгэ 7.12 сая төгрөгөөр нэмэгдэж, бусад сумдын өглөг 1.0 – 17.33 сая төгрөгөөр буурсан байна. Өглөг хэдийгээр буурсан үзүүлэлттэй байгаа ч аймаг, сумдын Засаг дарга нар Төсвийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.4 дэх “ Аймаг, Нийслэл, сум, дүүргийн Засаг дарга энэ хуулийн 61.1-д заасан чиг үүргийг төлөөлөн хэрэгжүүлэхэд дараах шаардлага тавигдана”, 39.4.2 дэх “Өр, авлага үүсгэхгүй байх” гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллах шаардлагатай байна.

Урт хугацаат өр төлбөрийн үлдэгдэл 3522.7 сая төгрөг нь орон нутгийн хотуудын нийтийн аж ахуйн хөгжлийн МОН-1907 төслийн хүрээнд хийгдсэн дэд бүтцийн ажлын зээлийн өглөг “Булган Мээж” ОНӨК-д бүртгэлтэй байна.

**Аудитын илрүүлэлт:**

